

ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

“Олон нийтийн радио телевизийн тухай хууль”-ийн хэлэлцүүлгийг Нээлттэй Нийгэм Форум, Глоб интернэшнл төв (ГИТ гэх) ТББ-тай хамтран 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн эхэнд ГИТ-ийн Удирдах зөвлөлийн дарга Х.Наранжаргал “Олон нийтийн өргөн нэвтрүүлэг: Түүхэн сургамж ба хуульд өөрчлөлт оруулах шаардлага”, ГИТ-ийн хуульч Б.Пүрэвсүрэн “Олон нийтийн радио телевизийн хуулийг олон нийтийн оролцоо, хяналтанд тулгуурлан шинэчлэх нь” сэдвээр танилцуулга хийлээ. Хэлэлцүүлэгт оролцогчид Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн ач холбогдлыг онцлохын зэрэгцээ, тус хууль нь олон нийтийн эрх ашигт үйлчилж, тэдний өмнө хариуцлага хүлээн, хяналт дор нь үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн радио, телевизийг бий болгож, бэхжүүлэх үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа тул шинэчлэн найруулах нь зүйтэй гэдэгтэй санал нэгдсэн юм. Хэлэлцүүлгээс гарсан, уг хуулийг өөрчлөн найруулахад зайлшгүй анхаарах шаардлагатай зарим санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

1.1 Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монголын радио 73, телевиз 38 жилийн босгон дээрээ олон нийтэд үйлчлэх зорилготой өргөн нэвтрүүлэг болсон нь ардчиллын жилүүдийн нэг том амжилт юм. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль хэрэгжсэн 15 жилийн хугацаанд 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ нэг ч удаа хийгдээгүй байна. Гэтэл Үндэсний зөвлөлийн сонгон шалгаруулалт шударга бус явагдсан, байгууллагын бүтэц хуулийн дагуу биш байна гэсэн

үндэслэлээр 2005 онд хамт олны зөвлөл байгуулагдаж, 2006 онд Түр хороо болон өөрчлөгдөж, 2007 онд 3 хоног үргэлжилсэн өлсгөлөн, мөн 5 минутын ажил хаялт тус тус зарлаж байжээ. Мөн адил үйл явдал 2020 онд Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ гэх)-д өрнөж байгаа нь олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн соёл бүрдээгүйтэй холбоотой гэж үзэхээр байна. Үүний нэг тод илрэл нь үе үеийн Үндэсний зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт байнга улс төрөөс хараат явж ирсэн явдал юм.

Санал: Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасны дагуу хуулийн хэрэгжилтийг үнэлэх сонгол зохион байгуулах.

- 1.2 ГИТ-ийн 2007 онд хийсэн мониторингоор МҮОНРТ-ийн Хяналтын зөвлөлийн 3 гишүүн бүгд Үндэсний зөвлөлийн гишүүд томилогдсон байсныг дурдсан байдаг. Мөн төрийн эдийн засгийн цензур байгааг ч өмнөх мониторинг, судалгааны дүнгүүд харуулдаг. Ялангуяа 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдал үндэсний телевизэд төрийн цензур бий болгосон.
- 1.3 Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Үндэсний зөвлөл дэргэдээ байгуулж болно” гэсэн заалтыг огт хэрэгжүүлээгүй явж ирсэн. Гэтэл олон улсын сайн туршлагаас харахад, тухайлбал, BBC, NHK нь тус бүр 110 хүнээс бүрдсэн зөвлөх хороотой байдаг байна.

Санал: Хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулах.

- 1.4 Сүүлийн жилүүдэд аливаа сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдийн тоо үлэмж нэмэгдсэнтэй холбоотойгоор сонгуулийн сурталчилгаанд дийлэнх цаг нь зарцуулагдах болсноор сонгогчдын боловсролд зориулагдсан нэвтрүүлэг 2016, 2020 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны үед ердөө 2-3 хувь байсан нь анхаарал татаж байна.
- 1.5 МҮОНРТ-ийн ажиллагсдын нийгмийн асуудал орхигдсон. Тусдаа хуультай гэх үндэслэлээр төрийн албаны бодлогоос тусдаа байдаг ч өөрийн хуульд нь энэ тухай огт тусгагдаагүй.

Санал: МҮОНРТ-ийн ажиллагсдын нийгмийн асуудлыг хуульчлан зохицуулах.

- 1.6 МҮОНРТ-ийн санхүүгийн өөр нэг эх үүсвэр бол иргэд, аж ахуйн нэгжээс авдаг хураамжийн орлого юм. Сарын хураамж 1100 төгрөг бөгөөд 2005 онд тогтоосноос хойш нэг ч удаа өөрчлөгдөлгүй өдийг хүрчээ. Мөн хураамжийг төлөхгүй байх нь ч нэмэгдэж байна. Энэхүү хураамж санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжиж орж ирдэг тул мөн л эдийн засгийн цензур болох эрсдэл дагуулдаг.

Санал: Хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-г заасан нэгжийг байгуулах, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах.

1.7 МҮОНРТ-ийн Ерөнхий захирал “Цагийн хүрд” мэдээний дарааллыг байнга шаардаж авах, нэвтрүүлгийн зочин хэн байхыг ч шийддэг. Мөн олон ургалч үзэл бодлыг хүндэтгэх үүрэгтэй ч нэг шашинд хэт давуу цаг олгох, мэдээний хөтөлбөр дундуур зар сурталчилгаа явуулах зэргээр нийтлэл нэвтрүүлгийн бодлого, редакцын хараат бус байдал алдагдаж байна.

Санал: Хуульд редакцын хараат бус байдлыг хангах зохицуулалтыг нэмж тусгах.

1.8 Төсвийн захиран зарцуулалт ил тод биш, тооцоо судалгаагүйгээр хэт олон телевиз, радиогийн сувгийг байгуулсан. Ажилтнуудын цалинг зөвшилцөлгүйгээр захиргааны санаачилгаар 20 хувь хассан.

Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
1	8.5	“...байгуулж болох...” гэдгийг “...байгуулах...” хэмээн өөрчлөх.	Бусад улс орны олон нийтийн өргөн нэвтрүүлэг зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй байгаа нь олон нийтэд үйлчлэх үүргээ хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй байдаг. Харин манай улсын хувьд тус заалт огт хэрэгжээгүй.
2	18.2	“...хэмжээг” гэсний дараа “инфляцын түвшинтэй уялдуулан, 5 жил тутамд шинэчлэх ажлыг” гэж нэмэх.	Анх 2005 онд 1100 хэмээн 1 ам.доллартой тэнцэх ханшаар тогтоосон бөгөөд 15 жилийн хугацаанд энэ дүнд огт өөрчлөлт ороогүй.
3	18.3	“байгуулж болох бөгөөд” гэснийг “байгуулах бөгөөд” гэх.	Учир нь одоог хүртэл тус нэгжийг байгуулаагүйн улмаас Сангийн ямаар дамжиж, энэ нь эдийн засгийн цензур болж ирсэн.
4	18.5	“бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий” гэснийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зохих нэршлээр солих.	Ялгаварлан гадуурхсан үг хэллэг тул.
5	21.4, 21.5, 21.6, 21.7, 21.9	Өөрчлөн найруулах.	Олон нийтийн өргөн нэвтрүүлгийг жинхэнэ утгаар хөгжүүлэхэд удирдах дээд байгууллагын сонгон шалгаруулалт, томилгоо хараат бус, олон нийтэд ил тод байх нь онцгой чухал ач холбогдолтой.
6		Үндэсний зөвлөл (ҮЗ)-ийн гишүүнд тавих шаардлагыг нэмэх.	
7		ҮЗ-ийн гишүүнийг иргэний нийгмийн төлөөлөл нэр дэвшүүлдэг байхыг хэвээр үлдээх.	

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
8		ҮЗ-ийн гишүүний бүрэн эрх дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хорооноос ҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.	
9		Гишүүнд тавих шаардлага хангасан хүний нэрийг иргэний нийгмийн төлөөлөл сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор гаргана.	
10		Төрийн байгуулалтын байнгын хороо Ажлын хэсэг байгуулж, 15 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна.	
11		Ажлын хэсэг шаардлага хангасан нэр дэвшигчдийн дунд томилгооны сонсгол зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан иргэдээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор нэр дэвшүүлж, Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцүүлнэ.	
12		Төрийн байгуулалтын байнгын хороо 7 хоногийн дотор хэлэлцэж, Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналаа Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.	
13		ҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй бол 14 хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан иргэдээс дарааллын зарчмаар өөр иргэний нэрийг дэвшүүлнэ.	
14		Нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй бол тухайн иргэнийг дахин нэр дэвшүүлэхгүй.	
15		ҮЗ-ийн гишүүнийг томилохдоо жендерийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.	
16		ҮЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Төрийн байгуулалтын байнгын хороо гаргана.	

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
17	25.10	Олон нийтэд үйлчлэх үүргээ хэрэгжүүлээгүй, хараат бус байдал алдагдсан, төрийн цензур тогтсон зэрэг асуудлаар хуралдах бол ҮЗ-ийн хуралдаан нээлттэй байна.	Шинээр нэмэх.
18	27.2	Өөрчлөн найруулах.	Хүн тус бүрийн орлого ялгамжтай байх тул адил ажил хийсний төлөө хэт ялгамжтай урамшуулах авахаар байна.
19	28 дугаар зүйл	Хяналтын зөвлөлд ҮЗ-ийн гишүүнийг сонгохыг хориглоно.	Шинээр нэмэх.
20		Хяналтын зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг нэмж тусгах.	Хяналт тавих чиг үүрэг тухайн асуудлаар мэргэшсэн байхыг шаардаж байгаа тул.
21	26.1.5	“6 сараас” гэснийг “3 сараас” гэж солих.	ҮЗ-ийн гишүүдийн хариуцлагыг өндөржүүлэх шаардлага байгааг харгалзан үзэх.
22	34.2	“...олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэснийг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлага байхгүй тул дээрх хуулийн үр нөлөө хангалтгүй байна.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд бие даасан зүйл болгож оруулах.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧИД

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, МҮОНРТ-ийг төлөөлж нийт 37 хүн оролцлоо. Үүнд:

Глоб интернэшнл төвийн Удирдах зөвлөлийн дарга Х.Наранжаргал, гүйцэтгэх захирал Т.Аюушжав, хуульч П.Пүрэвсүрэн, менежер Ч.Энхбаяр, Б.Онон

МҮОНРТ-ийн ажилтан Б.Пүрэв, Б.Баяртулга, Т.Эрдэнэчимэг, Р.Хонгорзул, Д.Мөнхшүр, П.Отгонтуяа

УЕПГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга Д.Дашмаа

Хууль зүйн нийгэмлэгийн ажилтан Д.Оросоо

Үндсэн уртраг ТББ-ын Гүйцэтгэх захирал С.Цэндбаатар

Сэтгэл зүйн мэдрэмж ТББ-ын Захирал Ч.Сэмжидмаа

Сити их сургуулийн багш Р.Оюунцэцэг

Эрхэмсэг тэмүүлэлт бүсгүйчүүд ТББ-ын ажилтан Б.Алтанцэцэг

Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбооны тэргүүн Ш.Ариунаа

МҮЭХ-ны Хуулийн бодлогын газрын дарга Ц.Отгонтунгалаг

Хөдөлмөр сонины сэтгүүлч Т.Солонго

Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийн гүйцэтгэх захирал Ц.Тамир

Хөгжлийн төлөөх судалгааны байгууллагын судлаач Д.Пунсанцогвоо

Жи энтертайнмент ХХК-ийн захирал Д.Ганболд

Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа

Монгол Улсын багшийн их сургуулийн Сэтгүүл зүйн багш н.Цэрэнжав

Метро ТВ&Радио байгууллагын ажилтан Т.Мөнхбат

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн багш Л.Ариунаа, эрхлэгч Л.Цэрэнжав

МУИС-ийн маркетингийн менежер Д.Удвал, докторант Д.Нарантуяа, Хууль зүйн сургуулийн оюутан М.Оюунхорол

ДХИС-ийн оюутан Б.Цэлмэг

Дачен Дентонс хуулийн фирмийн ахлах хуульч Т.Бат-Оргил, өмгөөлөгч Н.Чимэдрэгзэн, хуульч, өмгөөлөгч Б.Баттуяа

Сэтгүүлч Н.Болормаа

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн багш Я.Батбаяр

Нээлттэй Нийгэм Форумын Хуулийн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
*ННФ-ын Хуулийн
хөтөлбөрийн менежер*



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14240
Монгол Улс

Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

